



МОНГОЛ УЛС  
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2022 оны 07 сарын 21 өдөр


Дугаар А/469

Ховд

Хөрөнгө гаргах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1.17, 14.2.3, 41 дүгээр зүйлийн 41.2.2, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2021 оны 05/07 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Баруун бүсийн хурдан морины уралдаан, даншиг наадмын бэлтгэл хангах үйл ажиллагааны зардалд 3.000.000 төгрөг (гурван сая)-ийг хавсралтаар баталж, зарцуулсугай.
2. Зардалд зарцуулагдах 3.000.000 төгрөг (гурван сая)-ийг орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 2022 онд хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр арга хэмжээний жагсаалтын 4.7-д тусгагдсан төрийн үйлчилгээний чанар хүртээмжийг нэмэгдүүлэх дэд хөтөлбөрүүдийн санхүүжилтээс гаргахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (Ч.Багдал), Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн дарга (Б.Ганболд) нарт тус тус зөвшөөрсүгэй.
3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч дарга (Т.Дэлгэрсайхан)-д үүрэг болгосугай.



Б.ДҮГЭРЖАВ

8400 01 2362  
Zah A/469 tum